



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.06.09 № 08/ГЧ ЧАГ/САГ/2014/ЗЖИЛ

Г Зөрчил арилгуулах тухай

Засгийн газрын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сангийн сайдын 2007 оны 102, 114 дүгээр тушаалаар Өвөрхангай, Баянхонгор, Увс зэрэг аймгуудад улсын төсөвт төвлөрүүлэх ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос урьдчилан 1,538,213,904.26 төгрөг шилжүүлсэн байсанд 2012 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага барагдуулах төлбөрийн акт тавьсан байна.

Тайлант онд тухайн аймгуудын санхүүгийн дэмжлэгээс 169,736,556.90 төгрөгийг суутган тооцоолж үлдэгдэл 1,368,477,347.36 төгрөг байна. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан талаар шалгахад Баянхонгор аймаг 526,599,180.23 төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлээгүй, санхүүгийн тайлан балансд тусгаагүй байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3-д " төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагааг төсөвт тусгах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ НЬ**:

1. Баянхонгор аймгаас авах авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан, данс бүртгэлд нь тусгуулах,
2. Баянхонгор, Өвөрхангай аймгуудаас авах урьдчилгаа төлбөрийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч, биелэлтийг 2014 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ж.Ганбат нарт даалгав.

АХЛАХ АУДИТОР

УХА0122

Н.БАТСАЙХАН